

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зүүнговь сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/25/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Аудитор: Ч.Мөнхтогтох
Утас: 70453721, Цахим хаяг: Munkhtogtokhch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ЗҮҮНГОВЬ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Б.ЦЭЭЛЭЙНАМСАН
ТАНАА

2023.02.24 № УВА-2023/25/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зүүнговь сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зүүнговь сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200700573

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Дүгнэлтийн үндэслэл	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	3
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	31,686,431.00	159,209,597.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	20,000.00	0.00
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	20,000.00	0.00
31140	Касс арилжааны банк	20,000.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	31,666,431.00	159,209,597.00
35400	Хангамжийн материал	31,666,431.00	73,214,931.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,420,000.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	30,246,431.00	73,214,931.00
35600	Мал амьтад	0.00	85,994,666.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,672,181,142.33	2,605,969,053.08
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,672,181,142.33	2,605,969,053.08
39200	Биет хөрөнгө	2,650,109,142.25	2,583,897,053.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,573,517,529.00	1,618,517,529.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-235,514,976.22	-324,352,517.04
39203	Авто-тээврийн хэрэгсэл	134,299,800.00	137,299,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-88,469,879.88	-107,731,839.84
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	204,736,812.74	243,126,396.14
39206	Хуримтлагдсан элэгдэл	-174,799,903.48	-186,159,624.34
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	131,337,416.22	134,337,416.22
39208	Хуримтлагдсан элэгдэл	-90,584,020.22	-105,772,216.87
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,356,315,924.50	1,362,240,924.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	-160,729,560.41	-187,608,814.77
39300	Биет бус хөрөнгө	22,072,000.08	22,072,000.08
39301	Програм хангамж	2,055,000.00	2,055,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,054,999.92	-2,054,999.92
39303	Бусад биет бус хөрөнгө	22,072,000.00	22,072,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,703,867,573.33	2,765,178,650.08
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,226,921.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,226,921.00	0.00
41300	Өглөг	1,226,921.00	0.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,226,921.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,702,640,652.33	2,765,178,650.08
51	Засгийн газрын хувь оролцоо	2,702,640,652.33	2,765,178,650.08
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,228,902,865.00	1,228,902,865.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,228,902,865.00	1,228,902,865.00
51200	Хуримтлагдсан үр дүн	1,115,718,350.96	1,178,256,348.71

51210	Өмнөх үеийн үр дүн	1,185,790,916.16	1,115,718,350.96
51220	Тайлант үеийн үр дүн	-70,072,565.20	62,537,997.75
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	358,019,436.37	358,019,436.37
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,703,867,573.33	2,765,178,650.08

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	472,864,526.00	635,829,949.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,800,000.00	207,409,249.40
120	Нийтлэг татварын бус орлого	10,800,000.00	207,409,249.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	207,409,249.40
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	207,409,249.40
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	10,800,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	462,064,526.00	428,420,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	74,280,626.00	2,085,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,350,000.00	100,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	71,773,862.00	1,880,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,156,764.00	105,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	387,783,900.00	426,335,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	387,783,900.00	426,335,700.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	542,364,757.58	573,291,951.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	542,364,757.58	573,291,951.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	519,275,704.38	534,371,492.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	247,519,556.00	236,159,645.35
210101	Үндсэн цалин	247,519,556.00	178,766,341.63
210102	Нэмэгдэл	0.00	30,277,198.22
210104	Урамшуулал	0.00	2,786,131.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	24,329,974.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,451,775.80	29,414,250.25
210201	Тэтгэврийн даатгал	22,963,951.00	19,960,617.93
210202	Тэтгэмжийн даатгал	2,509,987.00	2,348,307.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,821,369.80	1,878,645.67
210204	Ажилгүйдлийн даатгал	464,553.00	459,972.97
210205	Эрүүл мэндийн даатгал	4,691,915.00	4,766,706.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,167,379.00	30,892,191.00
210301	Гэрэл, цахилгаан	4,374,029.00	7,489,441.00
210302	Түлш, халаалт	25,763,350.00	23,402,750.00
210303	Цэвэр, бохир ус	30,000.00	0.00

2104	Хангамж, бараа материалын зардал	20,411,961.00	38,009,333.00
210401	Бичиг хэрэг	2,692,330.00	2,874,800.00
210402	Тээвэр, шатахуун	15,867,470.00	31,328,365.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,653,161.00	1,686,568.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	76,000.00	620,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	123,000.00	1,499,600.00
2105	Нормативт зардал	450,000.00	0.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	450,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,550,100.00	7,241,000.00
210604	Урсгал засвар	1,550,100.00	7,241,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,506,000.00	4,816,000.00
210702	Дотоод албан томилолт	4,506,000.00	4,816,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,617,832.00	976,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,587,788.00	177,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	403,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	108,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	118,974.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	301,700.00	231,800.00
210807	Газрын төлбөр	63,720.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	176,601,100.58	186,862,772.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,096,460.00	25,136,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	180,000.00	200,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	163,324,640.58	161,526,672.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,089,053.20	38,920,459.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,473,400.00	23,726,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,653,400.00	16,737,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	820,000.00	6,989,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	15,194,159.40
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	15,194,159.40
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,615,653.20	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,115,647.20	0.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	500,006.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-69,500,231.58	62,537,997.75
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	572,333.62	0.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	572,333.62	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-70,072,565.20	62,537,997.75

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	462,064,526.00	428,420,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	462,064,526.00	428,420,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	74,280,626.00	2,085,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,350,000.00	100,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	71,773,862.00	1,880,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,156,764.00	105,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	387,783,900.00	426,335,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	387,783,900.00	426,335,700.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	381,662,664.00	417,140,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	381,662,664.00	417,140,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	358,573,610.80	378,220,240.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	244,350,534.80	237,553,537.54
210101	Үндсэн цалин	213,707,408.80	191,339,840.76
210102	Нэмэгдэл	157,500.00	25,349,181.78
210104	Урамшуулал	0.00	2,786,131.00
210105	Гэрээт ажлын хөлс	30,485,626.00	18,078,384.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,052,604.00	29,247,279.06
210201	Тэтгэврийн даатгал	23,279,204.00	19,960,617.93
210202	Тэтгэмжийн даатгал	2,447,600.00	2,348,307.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,957,980.00	1,878,645.67
210204	Ажилгүйдлийн даатгал	489,520.00	459,972.97
210205	Эрүүл мэндийн даатгал	4,878,300.00	4,599,735.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,206,349.00	30,892,191.00
210301	Гэрэл, цахилгаан	4,374,029.00	7,489,441.00
210302	Түлш, халаалт	26,802,320.00	23,402,750.00
210303	Цэвэр, бохир ус	30,000.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,919,991.00	26,709,433.00
210401	Бичиг хэрэг	2,678,830.00	2,874,800.00
210402	Тээвэр, шатахуун	12,968,500.00	19,727,765.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,658,661.00	1,686,568.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	167,000.00	1,085,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	447,000.00	1,334,600.00
2105	Нормативт зардал	450,000.00	0.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	450,000.00	0.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,761,100.00	10,556,000.00
210604	Урсгал засвар	1,761,100.00	10,556,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,506,000.00	4,816,000.00
210702	Дотоод албан томилолт	4,506,000.00	4,816,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,617,832.00	976,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,587,788.00	177,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	403,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	108,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	118,974.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	301,700.00	231,800.00
210807	Газрын төлбөр	63,720.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,709,200.00	37,469,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,529,200.00	37,269,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	180,000.00	200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,089,053.20	38,920,459.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,473,400.00	23,726,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,653,400.00	16,737,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	820,000.00	6,989,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	15,194,159.40
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	15,194,159.40
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,615,653.20	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,115,647.20	0.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	500,006.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	80,401,862.00	11,280,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	80,403,862.00	11,300,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	80,403,862.00	11,300,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	80,403,862.00	11,300,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	80,403,862.00	11,300,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-80,403,862.00	-11,300,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-2,000.00	-20,000.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	22,000.00	20,000.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	20,000.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,228,902,865.00	358,341,340.50	1,185,469,012.03	2,772,713,217.53
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	321,904.13	321,904.13
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,228,902,865.00	358,341,340.50	1,185,790,916.16	2,773,035,121.66
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-321,904.13	0.00	-321,904.13
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-70,072,565.20	-70,072,565.20
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,228,902,865.00	358,019,436.37	1,115,718,350.96	2,702,640,652.33
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,228,902,865.00	358,019,436.37	1,115,718,350.96	2,702,640,652.33
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,228,902,865.00	358,019,436.37	1,115,718,350.96	2,702,640,652.33
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	62,537,997.75	62,537,997.75
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,228,902,865.00	358,019,436.37	1,178,256,348.71	2,765,178,650.08

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	426,335,700.00	411,261,540.60	15,074,159.40	96.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	426,335,700.00	411,261,540.60	15,074,159.40	96.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	402,609,400.00	387,535,240.60	15,074,159.40	96.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	244,464,800.00	237,553,537.54	6,911,262.46	97.2
210101	Үндсэн цалин	224,304,800.00	191,339,840.76	32,964,959.24	85.3
210102	Нэмэгдэл	0.00	25,349,181.78	25,349,181.78	0.0
210104	Урамшуулал	0.00	2,786,131.00	-2,786,131.00	0.0
210105	Гэрээт ажлын хөлс	20,160,000.00	18,078,384.00	2,081,616.00	89.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,860,100.00	29,247,279.06	2,612,820.94	91.8
210201	Тэтгэврийн даатгал	21,664,900.00	19,960,617.93	1,704,282.07	92.1
210202	Тэтгэмжийн даатгал	2,548,800.00	2,348,307.08	200,492.92	92.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,039,000.00	1,878,645.67	160,354.33	92.1
210204	Ажилгүйдлийн даатгал	509,800.00	459,972.97	49,827.03	90.2

210205	Эрүүл мэндийн даатгал	5,097,600.00	4,599,735.41	497,864.59	90.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,523,200.00	30,892,191.00	631,009.00	98.0
210301	Гэрэл, цахилгаан	5,046,800.00	7,489,441.00	-2,442,641.00	148.4
210302	Түлш, халаалт	26,446,400.00	23,402,750.00	3,043,650.00	88.5
210303	Цэвэр, бохир ус	30,000.00	0.00	30,000.00	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	27,639,700.00	24,724,433.00	2,915,267.00	89.5
210401	Бичиг хэрэг	1,338,000.00	2,874,800.00	-1,536,800.00	214.9
210402	Тээвэр, шатахуун	18,802,600.00	18,947,765.00	-145,165.00	100.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,331,700.00	1,686,568.00	1,645,132.00	50.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,000,000.00	1,085,700.00	2,914,300.00	27.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	167,400.00	129,600.00	37,800.00	77.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,945,300.00	21,856,000.00	89,300.00	99.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,300,000.00	8,300,000.00	0.00	100.0
210602	Тавилга	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	10,645,300.00	10,556,000.00	89,300.00	99.2
2107	Томилолт, зочны зардал	5,366,600.00	4,816,000.00	550,600.00	89.7
210702	Дотоод албан томилолт	5,366,600.00	4,816,000.00	550,600.00	89.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,686,400.00	976,300.00	710,100.00	57.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	450,000.00	177,400.00	272,600.00	39.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	403,200.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	172,700.00	108,900.00	63,800.00	63.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	169,000.00	0.00	169,000.00	0.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	55,000.00	33,000.00	62.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	301,700.00	231,800.00	69,900.00	76.8
210807	Газрын төлбөр	101,800.00	0.00	101,800.00	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,123,300.00	37,469,500.00	653,800.00	98.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,656,800.00	37,269,500.00	387,300.00	99.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	466,500.00	200,000.00	266,500.00	42.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,726,300.00	23,726,300.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,726,300.00	23,726,300.00	0.00	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,737,300.00	16,737,300.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,989,000.00	6,989,000.00	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	426,335,700.00	411,141,541.40	15,194,158.60	96.4
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	426,335,700.00	411,141,541.40	15,194,158.60	96.4
320001	Орон нутгийн төсвөөс	426,335,700.00	411,141,541.40	15,194,158.60	96.4
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	20,000.00	-20,000.00	0.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.0

610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	26.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	8.00	8.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	9.00	9.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00	0.00	100.0
620004	Гэрээт ажилтан	7.00	7.00	0.00	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	26.00	26.00	0.00	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.00	9.00	0.00	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6.00	6.00	0.00	100.0
650010	Гэрээт ажилтан	4.00	4.00	0.00	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7.00	7.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	ТЗ цэвэр дүн / төгрөгөөр /
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		2,085,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,085,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,985,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		1,985,000.00
210402	Тээвэр, шатахуун		780,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,205,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		100,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		100,000.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		100,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		2,085,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		2,085,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		100,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,880,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		105,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орон нутгийн удирдлагыг мэдээлэл, бодлогын удирдамжаар ханган хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулан сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд ил тод нээлттэй, чанар, хүртээмжтэй хүргэх зорилготой байгууллага юм.

Тамгын газрын чиг үүргийн хувьд орон нутагт төрийн захиргааны удирдлага, төлөвлөлт санхүү, эдийн засгийн бодлого, нийгмийн бодлогын асуудлыг хариуцан төрийн хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, түүний хэрэгжилтийг хангуулах төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг хуулийн дагуу түргэн шуурхай, чанартай хүргэх, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчин бүрдүүлэхэд гол анхаарал хандуулан ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль,

Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, төсвийн тухай хууль, бусад хууль, тогтоомжуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ. Тайлант онд дотоод аудит хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Зүүнговь сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Зүүнговь сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэлээ.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн аливаа бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 61,311.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	20.0	0.0	-20.0
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	31,666.4	159,209.5	127,543.2
Үндсэн хөрөнгө	2,672,181.1	2,583,897.0	66,212.0
Нийт хөрөнгө	2,703,867.6	2,765,178.6	61,311.0
Өр төлбөр	1,226.9	0.0	-1,226.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,702,640.6	2,765,178.6	62,538.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,703,867.6	2,765,178.6	61,311.0

Мөнгөн хөрөнгийн 20.0 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Бараа материал дансны үлдэгдэл 159,209.5 мянган төгрөг болж 127,543.1 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй орлого хүлээн авч бусад бараа материал дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,583,897.0 мянган төгрөг болж 66,212.0 мянган төгрөгөөр өссөн нь ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн үндсэн хөрөнгө бүртгэж авснаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 0.0 мянган төгрөг болж 1,226.9 мянган төгрөгөөр буурсан нь цалингийн ашгийн өр төлбөрийг төлж бардуулснаас байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,765,178.6 мянган төгрөг болж 62,538.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Энэ нь хөрөнгө өссөнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 373,580.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналаас 52,755.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 426,335.7 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2022 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй эсвэл өмнөх оны төсвийн гүйцэтгэлд үндэслэснээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 52,755.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 426,335.7 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 413,261.5 мянган төгрөг буюу 97.6 хувьтай байгаа нь үндсэн дансны хэмнэгдэл байна. Үндсэн данснаас 15,194.1 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал 70106/80101	207,931.5	857,275.3	8,325.2	96.0
2	Баг, хорооны үйл ажиллагааны зардал 70106/80106	80,899.9	31,538.0	2,631.2	96.7
3	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал 70106/80111	41,180.5	78,869.9	611.3	98.5
4	Нийтлэг үйлчилгээ 70106/80112	30,690.7	30,558.5	132.2	99.6
5	Мэдээлэл, сурталчилгааны зардал 70106/80205	250.0	177.4	72.6	70.96
6	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг 70106/80802	6,989.0	6,989.0	0.0	100
7	Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох нөхөн олговор 70106/80815	16,737.3	16,737.3	0.0	100
8	Орон нутгийн нөөц хөрөнгө 70106/81102	31,656.8	31,656.8	0.0	100
9	Мал тооллого 70106/81507	1,400.0	1,399.0	1.0	100
10	Ахмадын сан 72208/81549	600.0	600.0	0.0	99.9
11	Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ 70106/82212	4,000.0	1,085.7	2,914.3	72.9
12	Улсын их баяр наадам 70106/82801	4,000.0	4,000.0	0.0	100
ДҮН		426,335.7	413,261.5	15,194.2	97.62

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 1,880.0 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 205.0 мянга, нийт 2,085.0 мянган төгрөг бүрдүүлжээ.

Үүнээс тээвэр шатахууны зардалд 780.0 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх зардалд 1,205.0 мянга нийт 1,985.0 мянган төгрөг зарцуулсан байна. Нэмэлт санхүүжилтийн данснаас 100.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Зүүнговь сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ч.Мөнхтогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Зүүнговь сумын Засаг даргын тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 31 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 541,874.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 573,291.9 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 5,732.9 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 4,586.3 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Зүүнговь сумын Засаг даргын тамгын газрын хувьд хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд биет горим сорилыг хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно. /АБ-4/

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаа хоцроосон 13, хугацаандаа 136 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байгаа тул зөвлөмж өглөө.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Зүүнговь сумын Засаг даргын тамгын газар нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Зүүнговь сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Зүүнговь сумын Засаг даргын тамгын газрын дансанд 3,000.0 мянган төгрөгийн мотоцикл, 78,000.0 мянган төгрөгийн хурган хуцыг бүртгэлд тусгасан. Үүнээс 78,000.0 мянган төгрөгийн хурган хуц биетээр байхгүй байна. Энэхүү асуудлыг Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийх гүйцэтгэлийн аудитаар шийдвэрлэхээр болов.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 377,541.1 мянган төгрөгийн алдаа 1 илэрснийг аудитын явцад залруулж, 1 зөрчилд зөвлөмж өглөө.

Үүнд: Үндсэн хөрөнгийн тайлангийн бусад үндсэн хөрөнгөнд 377,541.1 мянган төгрөгөөр сумын төвийн тохижилтыг орлого авсан байсныг Орон нутгийн өмчийн газрын албан бичгийн дагуу аудитын явцад залруулга хийлгэв.

1.1. Илрүүлэлт:

Зүүнговь сумын Засаг даргын тамгын газар нь Шилэн дансны цахим хуудсанд 13 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг хэрэгжүүлэн ажиллах

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн тодруулга тайлан	1	377,541.1					1	377,541.1				
Дүн	1	377,541.1					1	377,541.1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
13 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1	0.0					1	0.0
Дүн	1	0.0					1	0.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

/Ч.МӨНХТОГТОХ/

2023 оны 02 дугаар сарын 25-ны өдөр